



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ




Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

## АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ . . . . .	<b>3-4</b>
<b>НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ . . . . .</b>	<b>5</b>
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: . . . . .	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: . . . . .	10
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ . . . . .</b>	<b>11</b>
2.1. Нэгдсэн төсвийн орлого: . . . . .	11
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага: . . . . .	15
<b>ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА . . . . .</b>	<b>16</b>
3.1. Гадаад худалдааны эргэлт: . . . . .	16
3.2. Экспорт: . . . . .	18
3.3. Импорт: . . . . .	22
<b>ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ . . . . .</b>	<b>24</b>
4.1. Мөнгөний нийлүүлэлт: . . . . .	24
4.2. Гадаад валютын албан нөөц: . . . . .	27
4.3. Төлбөрийн тэнцэл: . . . . .	28
<b>ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ . . . . .</b>	<b>29</b>
5.1. Хүн ам, ажил эрхлэлт: . . . . .	29
5.2. Ажилгүйдэл: . . . . .	29



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



**Эдийн засаг 6.4 хувиар өсжээ.** 2022 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 1.9 хувьтай гарч байсан бол 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 6.4 хувь болж өссөн байна. Энэхүү өсөлтөд уул уурхай, тээвэр ба агуулах, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон нөлөөлжээ.

**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан байна.** 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 10,581.3 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 9,033.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,547.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 5.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 8.7 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 2,391.5 тэрбум төгрөгөөр өсөж, 1,547.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

**Төсвийн орлогын хувьд:** Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 10,581.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3,233.4 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай байна.

**Төсвийн нийт зарлагын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 2023 оны эхний хагас жилийн байдлаар 9,033.8 тэрбум төгрөгт хүрч, 85.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 841.9 тэрбум төгрөгөөр буюу 10.3 хувиар нэмэгдсэн байна.

**Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа.** 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 11,838.1 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 27.9 хувь буюу 2,581.6 сая ам.доллороор өсөж, гадаад худалдааны тэнцэл 3,290.8 сая ам.долларын ашигтай гарсан байна.

**Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 6 дугаар сарын байдлаар 31,448.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3,812.7 тэрбум төгрөг буюу 14.0 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 2,214.9 тэрбум төгрөг буюу 37.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

**Хэрэглээний үнийн индекс буурсан.** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 10.6 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 6.3 нэгж хувиар буурсан байна.

**Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа.** 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр урсгал тэнцэл 59.9 сая ам.долларын алдагдалтай, харин хөрөнгийн тэнцэл 21.8 сая ам.долларын ашигтай, санхүүгийн тэнцэл 132.8 сая ам.долларын ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 30.6 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлжээ.

**Гадаад валютын нөөц өслөө.** Нийт албан нөөцийн хэмжээ 2023 оны эхний хагас жилийн эцэст 3,818.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 721.0 сая ам.доллароор, 2022 оны эцэстэй харьцуулахад 418.0 сая ам.доллароор тус тус өссөн.

**Гадаад валютын ханш өнгөрсөн оны мөн үеэс суларсан хэдий ч өнгөрсөн саруудтай харьцуулахад чанаржсан байна.** 2023 оны 6 дугаар сард төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн сарын дундаж 3,438.0 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 314.0 төгрөгөөр суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 480.4 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.9 төгрөгөөр суларчээ. 2023 оны өмнөх сартай харьцуулахад ам.доллар 22.9 төгрөгөөр, юань 15.6 төгрөгөөр тус тус чангараад байна.

**Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өссөн байна.** 2023 оны 6 дугаар сарын байдлаар хугацаа хэтэрсэн зээл 1,325.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 221.2 тэрбум төгрөг буюу 20.0 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.2 хувийг эзэлж байна.

**Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ өсжээ.** Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ 2023 оны 6 дугаар сарын байдлаар 2.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 112.3 тэрбум төгрөг буюу 5.3 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 хувийг эзэлж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

## НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


#### Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2023 оны эхний хагас жилийн байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 13.6 их наяд төгрөг болж 6.4 хувьд хүрсэн байна.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улиралд өсөж 1.9 хувьд хүрч байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6.4 хувийн өсөлттэй гарлаа. График 1-д 2016-аас 2023 оны эхний хагас жилийн байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

Манай улсын гадаад эрэлтийг голлон тодорхойлогч БНХАУ-д “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалт суларсантай холбоотойгоор экспортын гол нэрийн барааны үнэ болон уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв сайжирч байна.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний хагас жилийн байдлаар оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 30.6 хувь буюу 7.1 их наяд төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 13.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.4 хувь буюу 0.8 их наяд төгрөгөөр өссөн байна.

Энэхүү өсөлтөд уул уурхай, тээвэр ба агуулах, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон нөлөөлжээ.


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 74.0 хувиар, уул уурхайн салбар 45.2 хувиар, бусад үйлчилгээ 24.6 хувиар тус тус өссөн бол хөдөө аж ахуйн салбар 9.9 хувиар буурчээ.

**Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн бүтэц, салбараар, нэгж хувиар**

Үзүүлэлт	2020				2021				2022				2023	
	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II
	<b>Эдийн засгийн өсөлтийн өөрчлөлт, салбараар /хувь/</b>													
ДНБ-ий бодит өсөлт	-10.1	-9.0	-6.7	-4.6	14.8	6.3	3.7	1.6	-3.8	2.0	3.8	5.0	7.9	6.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	12.0	12.4	10.8	5.8	-4.5	-4.6	-4.7	-5.5	11.3	11.4	10.2	12.0	-5.1	-9.9
Уул уурхай, олборлолт	-32.9	-31.5	-22.1	-9.9	38.5	23.5	10.9	0.8	-38.9	-30.7	-20.1	-15.3	49.8	45.2
Боловсруулах үйлдвэрлэл	1.2	-5.9	-5.8	3.4	23.8	11.8	5.3	-0.9	-10.1	-2.3	1.9	6.1	-6.8	1.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5.5	2.3	1.1	1.8	6.8	9.2	9.1	9.4	6.1	5.2	4.4	3.3	4.0	4.7
Барилга	13.0	-1.8	-1.9	-3.2	-0.4	-34.0	-30.2	-22.8	-29.8	-8.6	3.9	8.2	0.2	1.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	-13.6	-15.1	-14.8	-12.5	6.1	5.2	5.1	5.8	8.5	13.9	13.3	10.1	9.3	6.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-31.0	-32.2	-23.6	-18.2	18.7	10.1	0.6	-7.3	-31.9	-19.6	2.6	9.2	76.3	74.0
Мэдээлэл, холбоо	5.2	5.5	5.5	5.2	13.7	19.6	17.8	20.7	14.7	12.3	8.5	6.6	5.0	11.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-3.0	-4.3	-3.0	-2.6	0.8	0.3	2.0	3.8	4.3	5.1	4.3	5.4	1.2	1.9
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-8.1	-12.4	-8.8	-9.4	46.4	23.5	14.9	12.2	9.8	11.8	11.9	11.5	-3.6	2.5


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт, оны үнээр, их наяд төгрөгөөр**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**График 3. Бодит ДНБ, өөрчлөлт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**2021 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 6.3 хувьтай гарч байсан бол 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 1.9 хувьд хүрч буурсан ба энэ оны эхний улирлын байдлаар эдийн засаг 6.4 хувиар өссөн байна.**

**Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:**

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2023 оны эхний хагас жилийн байдлаар 30.6 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 34.7 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 13.3 их наяд төгрөг болж өнгөрсөн оноос 6.2 хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр**

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II	Өөрчлөлт (хувиар)
<b>ДНБ</b>	<b>17,652.6</b>	<b>17,134.2</b>	<b>19,563.9</b>	<b>22,746.9</b>	<b>30,649.1</b>	<b>34.7</b>
<b>Эцсийн хэрэглээ</b>	<b>12,771.5</b>	<b>14,169.5</b>	<b>13,382.1</b>	<b>16,419.0</b>	<b>19,295.5</b>	<b>17.5</b>
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	10,372.3	11,424.8	10,832.8	13,475.6	15,357.6	14.0
Төрийн байгууллагын хэрэглээ	2,399.2	2,744.6	2,549.3	2,943.3	3,937.9	33.8
<b>Хөрөнгийн нийт хуримтлал</b>	<b>5,275.7</b>	<b>4,511.5</b>	<b>6,552.8</b>	<b>9,487.7</b>	<b>8,107.1</b>	<b>-14.6</b>
Үндсэн хөрөнгийн хуримтлал	4,636.4	3,932.0	4,851.6	5,659.1	7,526.3	33.0
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	639.4	579.5	1,701.2	3,828.6	580.9	-84.8
<b>Цэвэр экспорт</b>	<b>-394.6</b>	<b>-1,546.8</b>	<b>-371.0</b>	<b>-3,159.8</b>	<b>3,246.5</b>	<b>-202.7</b>
Бараа, үйлчилгээний экспорт	11,213.5	8,082.0	11,325.0	12,422.0	26,178.2	110.7
Бараа, үйлчилгээний импорт	11,608.1	9,628.8	11,696.0	15,581.7	22,931.7	47.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр**


/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II	Өөрчлөлт (хувиар)
<b>ДНБ</b>	<b>12,793.5</b>	<b>11,831.6</b>	<b>12,562.5</b>	<b>12,542.3</b>	<b>13,315.2</b>	<b>6.2</b>
<b>Эцсийн хэрэглээ</b>	<b>10,718.1</b>	<b>11,471.2</b>	<b>10,446.9</b>	<b>11,211.7</b>	<b>11,879.9</b>	<b>6.0</b>
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	8,619.5	9,166.3	8,320.6	8,943.1	9,183.4	2.7
Төрийн байгууллагын хэрэглээ	2,098.5	2,304.9	2,126.3	2,268.7	2,696.5	18.9
<b>Хөрөнгийн нийт хуримтлал</b>	<b>4,422.4</b>	<b>3,308.5</b>	<b>4,786.6</b>	<b>6,581.5</b>	<b>4,666.8</b>	<b>-29.1</b>
Үндсэн хөрөнгийн хуримтлал	3,838.2	3,043.3	3,426.3	3,896.0	4,229.1	8.6
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	584.3	265.2	1,360.4	2,685.6	437.7	-83.7
<b>Цэвэр экспорт</b>	<b>-2,347.0</b>	<b>-2,948.1</b>	<b>-2,671.1</b>	<b>-5,251.0</b>	<b>-3,231.4</b>	<b>-38.5</b>
Бараа, үйлчилгээний экспорт	6,994.1	5,120.4	5,836.3	5,005.0	10,656.3	112.9
Бараа, үйлчилгээний импорт	9,341.1	8,068.5	8,507.3	10,256.0	13,887.7	35.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад эдийн засгийн бодит өсөлт 6.2 хувиар /эцсийн ашиглалтын аргаар тооцсон/ өсөхөд өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4. ДНБ-ий бодит өсөлт, салбараар, хувиар

Үзүүлэлт	2021				2022				2023	
	I	II	III	IV	I	II	III	IV	I	II
<b>ДНБ</b>	<b>15.1</b>	<b>6.2</b>	<b>3.4</b>	<b>1.6</b>	<b>-2.5</b>	<b>-0.2</b>	<b>2.6</b>	<b>5.0</b>	<b>7.8</b>	<b>6.2</b>
<b>Эцсийн хэрэглээ</b>	<b>-11.4</b>	<b>-8.9</b>	<b>-8.3</b>	<b>-2.7</b>	<b>8.6</b>	<b>7.3</b>	<b>7.4</b>	<b>7.8</b>	<b>2.6</b>	<b>6.0</b>
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	-11.6	-9.2	-8.4	-5.9	9.3	7.5	7.8	8.1	-0.1	2.7
Төрийн байгууллагын хэрэглээ	-10.6	-7.7	-8.0	9.2	5.3	6.7	5.7	6.9	14.8	18.9
<b>Хөрөнгийн нийт хуримтлал</b>	<b>29.2</b>	<b>44.7</b>	<b>78.2</b>	<b>80.7</b>	<b>31.4</b>	<b>37.5</b>	<b>8.8</b>	<b>11.2</b>	<b>-16.4</b>	<b>-29.1</b>
Үндсэн хөрөнгийн хуримтлал	12.2	12.6	2.8	17.7	1.9	13.7	14.4	13.2	16.2	8.6
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	249.4	412.9	-1,210.6	-1,403.0	153.6	97.4	-0.1	6.8	-70.7	-83.7
<b>Цэвэр экспорт</b>	<b>-47.3</b>	<b>-9.4</b>	<b>55.0</b>	<b>142.2</b>	<b>106.3</b>	<b>96.6</b>	<b>27.8</b>	<b>23.9</b>	<b>-31.2</b>	<b>-38.5</b>
Бараа, үйлчилгээний экспорт	81.9	14.0	-9.0	-14.6	-29.3	-14.2	26.0	32.3	135.4	112.9
Бараа, үйлчилгээний импорт	11.0	5.4	8.5	13.6	6.1	20.6	26.7	29.1	50.9	35.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## 1.2. Нэг хүнд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Монгол Улсын хувьд, Үндэсний статистикийн хорооноос 2015 оноос хойш улирал бүр уул уурхай, аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын бүтээмжийн талаарх статистик тоон мэдээллийг нийтэлдэг болсон.

Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр нэг ажиллагчид ногдох ДНБ-ээр илэрхийлэн тооцоолж байна.

Бүтээмж 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар буюу 374.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Салбараар нь авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж 3.4 сая төгрөг (37.2 хувь), аж үйлдвэр, барилгын салбар 497.8 мянган төгрөг (14.9 хувь), үйлчилгээний салбар 345.6 мянган төгрөг (7.0 хувь)-өөр тус тус нэмэгдсэн боловч хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 778.7 мянган төгрөг (11.5 хувь)-өөр буурчээ.

### Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

/мянган төгрөгөөр/

Бүрэлдэхүүн	Эхний хагас жилийн байдлаар				Өөрчлөлт 2023/2022	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
<b>Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин</b>	<b>5,684.9</b>	<b>6,156.4</b>	<b>6,244.8</b>	<b>6,619.0</b>	<b>374.2</b>	<b>6.0</b>
Хөдөө аж ахуй	6,792.3	6,004.2	6,780.4	6,001.7	-778.7	-11.5
Уул уурхай, олборлолт	12,062.6	12,626.7	9,230.7	12,662.0	3,431.3	37.2
Аж үйлдвэр, барилга	4,011.5	3,644.0	3,333.4	3,831.2	497.8	14.9
Үйлчилгээ	3,859.4	4,706.4	4,906.1	5,251.7	345.6	7.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 10,581.3 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 9,033.8 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,547.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3,233.4 тэрбум төгрөг буюу 44.0 хувиар, төсвийн нийт зарлага 841.9 тэрбум төгрөг буюу 10.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

**Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв**

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	Өөрчлөлт(+/-)	
		2023.06/2022.06				
	1	2	3	(3:1)	(3-2)	(3-2)/2
	2023.06	2022.06	2023.06	Төл/гүйц	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	10,578.8	7,347.9	10,581.3	100.0	3,233.4	44.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	10,523.8	8,191.9	9,033.8	85.8	841.9	10.3
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	55.0	-844.0	1,547.5	2,813.5	2,391.5	-283.4
ДНБ, оны үнээр		23,352.6	30,495.8		7,143.3	
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		-3.6	5.1		8.7	

Эх сурвалж: Сангийн яам

2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,547.5 тэрбум төгрөгийн ашигтай гарч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 5.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 8.7 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 2,391.5 тэрбум төгрөгөөр өсөж, 1,547.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

**2.1. Нэгдсэн төсвийн орлого:**

**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 10,581.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 44.0 хувиар буюу 3,233.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 2.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.**

Тэнцвэржүүлсэн нийт орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл орон нутгийн төсөв 2.2 хувь буюу 41.3 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 0.8 хувь буюу 5.7 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 3.6 хувь буюу 65.6 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол улсын төсөв 6.9 хувь буюу 532.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 64.4 хувь буюу 2,833.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 49.0 хувь буюу 632.7 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сан 16.5 хувь буюу 269.1 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 6.0 хувь буюу 43.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн орлогын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, төсвийн шатлалаар**

/тэрбум төгрөгөөр/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>7,879.4</b>	<b>7,713.0</b>	<b>1,883.5</b>		<b>1,834.3</b>		<b>760.7</b>	<b>766.4</b>
Ирээдүйн өв сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	112.3	477.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>7,767.1</b>	<b>7,235.1</b>	<b>1,883.5</b>		<b>1,834.3</b>		<b>760.7</b>	<b>766.4</b>
Татварын орлого	6,725.9	6,554.7	1,364.6	1,491.1	1,515.4	1,591.0	760.7	766.4
Татварын бус орлого	1,041.2	680.4	518.9	433.7	318.9	308.9	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам


Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 93.0 хувийг татварын орлого, 7.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.

*Нэгдсэн төсвийн татварын орлого 9,841.2 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 0.5 хувиар буюу 48.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол өмнөх оны мөн үеэс 41.8 хувь буюу 2,900.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.*

2023 онд Тогтворжуулалтын санд 132.7 тэрбум, Ирээдүйн өв санд 540.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс энэ оны эхний хагас жилийн байдлаар Тогтворжуулалтын санд 477.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 325.5 хувь буюу 365.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

**Татварын орлого:** Татварын орлогын 25.9 хувийг орлогын албан татвар, 18.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 2.0 хувийг хөрөнгийн албан татвар, 22.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 3.8 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 7.0 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 20.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

**График 5. Татварын орлогын бүтэц, хувиар**



Эх сурвалж: Сангийн яам


2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр татварын орлого төлөвлөснөөс 0.5 хувь буюу 48.8 тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 7.5 хувь (178.7 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 5.5 хувь (93.6 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 28.7 хувь (44.2 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 4.8 хувь (100.5 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр татварын орлого 41.8 хувь буюу 2,900.5 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 64.3 хувь (998.9 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 29.5 хувь (409.0 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 60.5 хувь (74.9 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 20.9 хувь (377.5 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 17.7 хувь (103.0 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 101.3 хувь (1,028.4 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 9.1 хувь (0.9 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

**Татварын бус орлого 740.2 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 332.9 тэрбум төгрөгөөр буюу 81.8 хувиар өссөн бол төлөвлөснөөс 46.3 тэрбум төгрөг буюу 5.9 хувиар дутцуу төвлөрчээ.**

**Татварын бус орлого:** Татварын бус орлогын 83.8 хувийг нийтлэг татварын бус орлого, 16.0 хувийг тусламжийн орлого, 0.2 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 36.0 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 23.2 хувийг газрын тосны орлого, 10.6 хувийг торгуулийн орлого, 10.0 хувийг бусад орлого, 7.8 хувийг хүүгийн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого бүрдүүлж байна.

**График 6. Татварын бус орлогын бүтэц, хувиар**



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад гадаад хандив тусламжийн орлого 17.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 2.7 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 42.0 тэрбум төгрөг, торгуулийн орлого 43.1 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашгийн орлого 11.4 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 0.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол хүүгийн орлого 68.2 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 22.0 тэрбум төгрөгөөр, бусад орлого 15.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

Харин навигацийн орлого тайлант хугацаанд төвлөрөөгүй байна.

## 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 10,523.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 85.8 хувийг зарлагадаж, 1,490.0 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 841.9 тэрбум төгрөг буюу 10.3 хувиар өсөж, 9,033.8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

### Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл /2022.06/	2023 оны эхний хагас жилийн байдлаар			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	8,191.9	10,523.8	9,033.8	85.8	-1,490.0
Нийт зарлага	8,163.7	10,562.0	9,000.5	85.2	-1,561.5
Урсгал зардал	7,004.8	8,730.9	7,556.6	86.6	-1,174.3
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,640.0	2,635.1	2,044.6	77.6	-590.5
Хүү	415.6	643.2	513.8	79.9	-129.4
Татаас	267.9	368.0	266.5	72.4	-101.5
Урсгал шилжүүлэг	4,681.3	5,084.7	4,731.8	93.1	-352.9
Хөрөнгийн зардал	1,158.9	1,831.1	1,443.9	78.9	-387.2
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	28.2	-38.2	33.3	87.2	71.5

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 551.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 83.6 хувь буюу 7,556.6 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 62.6 хувийг урсгал шилжүүлэг, 27.1 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.8 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.5 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татаас 1.5 тэрбум төгрөгөөр буурсан ч бараа, ажил үйлчилгээний зардал 404.7 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 98.2 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлэг 50.4 тэрбум төгрөгөөр өссөн тус тус өссөн байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 284.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

## ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

### 3.1. Гадаад худалдааны эргэлт:

**Монгол Улс 2023 оны эхний хагас жилд 140 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 11,838.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2,581.6 сая ам.доллар буюу 27.9 хувиар өссөн байна. Үүнд экспорт 2,256.1 сая ам.доллаар, импорт 325.5 сая ам.доллаар өссөн байна.**

2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр экспорт импортын дүнгээс 3,290.8 сая ам.доллаар давж, экспортын худалдаа 7,564.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 42.5 хувиар, мөн импорт 4,273.6 сая ам.долларт хүрч, 8.2 хувиар нэмэгдсэн нь гадаад худалдааны ашгийг 1,930.6 сая ам.доллаар буюу 2.4 дахин нэмэгдүүлсэн байна.

#### Хүснэгт 9. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
<b>Нийт эргэлт</b>	<b>6,832.8</b>	<b>5,288.3</b>	<b>7,372.4</b>	<b>9,256.4</b>	<b>11,838.1</b>	<b>2,581.6</b>	<b>27.9</b>
Экспорт	3,939.0	2,828.2	4,111.3	5,308.3	7,564.4	2,256.1	42.5
Импорт	2,893.8	2,460.1	3,261.1	3,948.1	4,273.6	325.5	8.2
<b>Тэнцэл</b>	<b>1,045.2</b>	<b>368.0</b>	<b>850.2</b>	<b>1,360.2</b>	<b>3,290.8</b>	<b>1,930.6</b>	<b>141.9</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,930.6 сая ам.доллаар өсөж 3,290.8 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад худалдааны ашиг өмнөх оны мөн үеэс 1,930.6 сая ам.доллаар буюу 2.4 дахин өссөн байна.

**Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл:** Валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 99.0 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 96.7 хувийг тус тус эзэлж байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2023 оны эхний хагас жилийн байдлаар 3,368.0 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 1,941.2 сая ам.доллаар өссөн байна.

Валютын төлбөртэй барааны тэнцэл өсөхөд валютын төлбөртэй экспорт 2,210.2 сая ам.доллаар, валютын төлбөртэй импорт 268.9 сая ам.доллаар нэмэгдсэн нь нөлөөлжээ.



**Хүснэгт 10. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл**


/сая.ам.доллаароор/

Үзүүлэлт	Эхний хагас жил		Өөрчлөлт	
	2022	2023	Дүн	Хувь
<b>А.Экспорт</b>	<b>5,308.3</b>	<b>7,564.4</b>	<b>2,256.1</b>	<b>42.5</b>
Валютын төлбөртэй бараа	5,281.8	7,492.0	2,210.2	41.8
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	99.5	99.0	-0.5	-0.5
<b>Б.Импорт</b>	<b>3,948.1</b>	<b>4,273.6</b>	<b>325.5</b>	<b>8.2</b>
Валютын төлбөртэй бараа	3,855.1	4,124.0	268.9	7.0
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	97.6	96.5	-1.1	-1.2
<b>Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл</b>	<b>1,426.7</b>	<b>3,368.0</b>	<b>1,941.2</b>	<b>136.1</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Экспорт, импортын жилийн өсөлт:** Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2023.06)-аар тооцон үзэв. 2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

**График 7. Гадаад худалдааны үзүүлэлт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Хөрш орнуудтай хийсэн худалдаа:** Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт болон импортын худалдаанд хөрш ОХУ болон БНХАУ томоохон хувийг эзэлдэг. Тухайлбал, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөрш орнууд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 82.7 хувь, экспортын 92.4 хувь, импортын 65.6 хувийг тус тус эзэлж байна. 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 72.7 хувь буюу 8,610.4 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, мөн 10.0 хувь буюу 1,185.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийсэн байна. Харин бусад улс оронтой хийсэн худалдаа нийт бараа эргэлтийн 17.3 хувийг эзэлж байна. БНХАУ нийт экспортын 91.8 хувь /6.9 тэрбум ам.доллар/, нийт импортын 39.0 хувь /1.7 тэрбум ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ-ын хувьд нийт экспортын 0.6 хувь, нийт импортын 26.6 хувь /1.1 тэрбум ам.доллар/-ийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 11. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт**

/сая ам.доллар/

Улс орон	Төрөл	Эзлэх хувь /2023.06 сар/	Эхний хагас жилийн байдлаар				Өөрчлөлт (+/-)	
			2020	2021	2022	2023	2023.06/2022.06	
			Дүн		Хувь			
БНХАУ	Нийт эргэлт	72.7	2,963.7	5,004.3	5,746.5	8,610.4	2,863.9	49.8
	Экспорт	91.8	2,113.3	3,705.1	4,374.8	6,945.6	2,570.8	58.8
	Импорт	39.0	850.4	1,299.3	1,371.7	1,664.8	293.1	21.4
	Тэнцэл	-	1,262.9	2,405.8	3,003.1	5,280.8	2,277.7	75.8
ОХУ	Нийт эргэлт	10.0	699.3	897.5	1,248.2	1,185.1	-63.1	-5.1
	Экспорт	0.6	24.4	50.0	35.4	48.5	13.1	37.1
	Импорт	26.6	675.0	847.5	1,212.8	1,136.6	-76.2	-6.3
	Тэнцэл	-	-650.6	-797.5	-1,177.4	-1,088.1	89.3	-7.6
Бусад	Нийт эргэлт	17.3	1,625.3	1,470.6	2,261.7	2,042.6	-219.1	-9.7
	Экспорт	7.5	690.5	356.2	898.1	570.4	-327.8	-36.5
	Импорт	34.4	934.8	1,114.3	1,363.6	1,472.3	108.7	8.0
	Тэнцэл	-	-244.3	-758.1	-465.4	-901.9	-436.5	93.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний хагас жилийн байдлаар БНХАУ-тай хийсэн худалдаа 5,280.8 сая ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа -1,088.1 сая ам.долларын, бусад орнуудтай хийсэн худалдаа -901.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

**3.2. Экспорт:**

*Экспортын худалдаа 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7,564.4 сая ам.доллар болж, Ковид-19-ын цар тахлын үе буюу 2020 оны мөн үетэй харьцуулахад 4,736.3 сая ам.доллар буюу 2.7 дахин өссөн бол 2022 оны мөн үеэс 2,256.1 сая ам.доллар буюу 42.5 хувиар өссөн байна.*

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрдсийн бүтээгдэхүүний экспорт 6,595.3 сая ам.доллар болж, 2,158.2 сая ам.доллар буюу 48.6 хувиар өссөн, харин эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 969.2 сая ам.долларт хүрч, 98.0 сая ам.доллар буюу 11.2 хувиар өссөн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 87.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Тухайлбал, өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспортын хэмжээ 2.3 сая барр-иар буюу 20.8 дахин, нүүрсний экспортын хэмжээ 21.4 сая/тн-оор буюу 3.6 дахин өссөн байна.

**Хүснэгт 12. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт**


/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	3,307.5	2,020.6	3,389.4	4,437.1	6,595.3	2,158.2	48.6	87.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	631.5	807.6	721.9	871.2	969.2	98.0	11.2	12.8
<b>Нийт экспорт</b>	<b>3,939.0</b>	<b>2,828.2</b>	<b>4,111.3</b>	<b>5,308.3</b>	<b>7,564.4</b>	<b>2,256.1</b>	<b>42.5</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт экспортын орлогын 58.2 хувийг нүүрсний, 17.6 хувийг зэсийн баяжмалын, 4.5 хувийг боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны, 3 хувийг төмрийн хүдрийн, 2.3 хувийг боловсруулаагүй нефтийн экспортын орлого эзэлж байна.


**График 8. Гол нэр төрлийн барааны экспорт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Доорх графикуудаар зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн экспортын орлого, тоо хэмжээ болон үнийн өөрчлөлтийг бүтээгдэхүүн бүрээр харууллаа.

**График 9. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**График 10. Нүүрсний экспортын өөрчлөлт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**График 11. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Хүснэгт 13. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр**

Гол нэр төрлийн бараа	Хэмжих нэгж	Эхний хагас жилийн байдлаар				Өмнөх оны мөн үеэс	
		2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	тн	11.0	3.7	8.6	5.4	-3.2	-37.1
Зэсийн баяжмал	мян.т	675.9	614.9	747.8	764.3	16.5	2.2
Төмрийн хүдэр, баяжмал, пирит	мян.т	4,124.3	4,028.6	1,750.3	2,681.0	930.7	53.2
Цайрын баяжмал	мян.т	66.6	66.7	73.4	100.1	26.8	36.5
Нүүрс	мян.т	8,676.2	9,594.7	8,080.3	29,520.0	21,439.7	3.6 дахин
Боловсруулаагүй нефть	мян.барр	951.1	2,858.5	114.1	2,373.0	2,258.9	20.8 дахин

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Хүснэгт 14. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого**

/сая ам.доллар/

Гол нэр төрлийн бараа	Эхний хагас жилийн байдлаар				Өмнөх оны мөн үеэс	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	606.4	218.0	514.1	337.6	-176.5	-34.3
Зэсийн баяжмал	741.1	1,312.9	1,590.7	1,329.8	-260.9	-16.4
Төмрийн хүдэр, баяжмал, пирит	283.2	550.8	173.9	229.2	55.3	31.8
Цайрын баяжмал	80.1	101.1	155.2	164.2	9.0	5.8
Нүүрс	690.8	1,026.9	2,349.7	4,393.7	2,044.0	87.0
Боловсруулаагүй нефть	34.0	168.4	12.3	176.3	163.9	14.3 дахин

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 2,158.2 сая ам.доллар буюу 48.6 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**Нүүрс:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар 29.5 сая тонн нүүрс экспортолж, 4,393.7 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үеэс экспортын биет хэмжээ 3.6 дахин өсөж, нүүрсний экспортын орлого 2,044.0 сая ам.доллараар буюу 87 хувиар өссөн байна.

**Боловсруулаагүй нефть:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар боловсруулаагүй нефтийн экспорт 2373.0 мянган баррель буюу 176.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14.3 дахин өссөн байна. Нэг баррель нефтийн дундаж үнэ 108.0 ам.доллараас 74.3 ам.доллар болж буурчээ.

**Төмрийн хүдэр:** 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 2681.0 мян.тонн төмрийн хүдэр экспортолж, 229.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс төмрийн хүдрийн экспортын орлого 31.8 хувь буюу 55.3 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 53.2 хувь буюу 930.7 мян.тн-оор өссөн нь нөлөөлжээ. Экспортын дундаж үнэ 85.5 ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 13.9 ам.доллараар буурчээ. Төмрийн хүдрийг 100.0 хувь БНХАУ-д экспортолсон байна.

**Цайрын баяжмал:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 100.1 мянган тоннд хүрч, 164.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын биет хэмжээ 36.5 хувь буюу 26.8 мянган тонноор өссөн нь цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 5.8 хувь буюу 9.0 сая ам.доллараар өсөхөд нөлөөлжээ. Харин цайрын баяжмалын хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 475.6 ам.доллараар буюу 22.5 хувиар буурсан байна

**Харин дараах эрдэс бүтээгдэхүүний экспортын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна. Үүнд:**

**Алт:** 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 5.4 тонн алт экспортолж, экспортын орлого 337.6 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 34.3 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үеэс алтны экспортын биет хэмжээ 37.1 хувиар буурсан нь алтны экспортын орлогыг бууруулжээ.

**Зэсийн баяжмал:** 2023 оны эхний хагас жилийн байдлаар 764.3 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, экспортын орлого 1,329.8 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 16.4 хувиар буурсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 16.5 мянган тонноор өсөж, экспортын орлого 260.9 сая ам.доллаар, хилийн дундаж үнэ нь 387.2 ам.доллараар тус тус буурчээ. 2023 оны эхний хагас жилийн байдлаар зэсийн баяжмалыг 99.9 хувь БНХАУ-д гаргасан байна.

**3.3. Импорт:**

**2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт импортын худалдаа 4,273.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.2 хувь буюу 325.5 сая ам.доллаар өссөн үзүүлэлттэй байна.**

Нийт импортын 23.6 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 76.4 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,008.9 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 131.5 сая ам.доллар буюу 15.0 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 3,264.7 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 194.1 сая ам.доллар буюу 6.3 хувиар өсжээ.

**Хүснэгт 15. Эрдсийн бүтээгдэхүүний импорт**

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	621.9	485.4	551.9	877.5	1,008.9	131.5	15.0	23.6
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	2,271.9	1,974.8	2,709.2	3,070.7	3,264.7	194.1	6.3	76.4
<b>Нийт импорт</b>	<b>2,893.8</b>	<b>2,460.1</b>	<b>3,261.1</b>	<b>3,948.1</b>	<b>4,273.6</b>	<b>325.5</b>	<b>8.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт импортын 29.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 41.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 9.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 21.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна.

## Хүснэгт 16. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


Бүтээгдэхүүн	Эхний хагас жилийн байдлаар						Өөрчлөлт (сая ам.дол)
	2021		2022		2023		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	2023/2022
<b>Хэрэглээ</b>	<b>1,002.0</b>	<b>31</b>	<b>1,308.0</b>	<b>33</b>	<b>1,244.0</b>	<b>29</b>	<b>-64.0</b>
- Түргэн эдэлгээтэй	619.0	19	725.0	18	621.0	15	-104.0
- Удаан эдэлгээтэй	383.0	12	583.0	15	623.0	15	40.0
<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>1,409.0</b>	<b>43</b>	<b>1,420.0</b>	<b>36</b>	<b>1,745.0</b>	<b>41</b>	<b>325.0</b>
- Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	977.0	30	767.0	19	1,123.0	26	356.0
- Барилгын материал	292.0	9	496.0	13	481.0	11	-15.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	140.0	4	157.0	4	141.0	3	-16.0
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>383.0</b>	<b>12</b>	<b>442.0</b>	<b>11</b>	<b>398.0</b>	<b>9</b>	<b>-44.0</b>
- Хүнсний орц	82.0	3	13.0	0	21.0	0	8.0
- Химийн бүтээгдэхүүн	61.0	2	94.0	2	73.0	2	-21.0
- Цахилгаан эрчим хүч	75.0	2	89.0	2	95.0	2	6.0
- Бусад АҮ-ийн орц	165.0	5	246.0	6	209.0	5	-37.0
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>460.0</b>	<b>14</b>	<b>766.0</b>	<b>19</b>	<b>880.0</b>	<b>21</b>	<b>114.0</b>
- Дизель	263.0	8	394.0	10	523.0	12	129.0
- АИ-92, 95	102.0	3	260.0	7	244.0	6	-16.0
- А80 ба бусад	95.0	3	112.0	3	113.0	3	1.0
<b>Нийт дүн</b>	<b>3,261.0</b>		<b>3,948.0</b>		<b>4,274.0</b>		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

2022 оны мөн үетэй харьцуулахад 2023 оны эхний хагас жилийн байдлаар импортын худалдаа 326.0 сая ам.доллороор нэмэгдэхэд хөрөнгө оруулалт 325.0 сая, нефтийн бүтээгдэхүүн 114.0 сая ам.доллороор тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүний дотор машин, механик тоног төхөөрөмж, эд анги 356.0 сая ам.доллар, дизель түлш 129.0 сая ам.доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 40.0 сая ам.доллороор тус тус нэмэгдсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оны мөн үеэс 114.0 сая ам.доллороор өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан хэдий ч тоо хэмжээ 27.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Дизель түлшний импорт 129.0 сая ам.доллороор нэмэгджээ. 2023 оны 6 дугаар сарын байдлаар нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 113.2 ам.дол/баррель болж, өмнөх оны мөн үеэс 11.5 ам.доллар буюу 9.2 хувиар буурсан байна.

**График 12. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ**



## ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 4.1. Мөнгөний нийлүүлэлт:

**Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 31,448.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3,812.7 тэрбум төгрөг буюу 14.0 хувиар өссөн байна.**

Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 2,214.9 тэрбум төгрөг буюу 37.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

### Хүснэгт 17. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар			Өөрчлөлт (+/-)	
				2023/2022	
	2021	2022	2023	Дүн	Хувь
<b>Мөнгөний нийлүүлэлт (М2)</b>	<b>27,974.0</b>	<b>27,635.5</b>	<b>31,448.2</b>	<b>3,812.70</b>	<b>14.0</b>
<b>Мөнгө М1</b>	<b>5,980.0</b>	<b>6,067.1</b>	<b>8,282.0</b>	<b>2,214.90</b>	<b>37.0</b>
Төгрөгийн харилцах	5,095.6	5,309.8	7,459.6	2,149.80	40.0
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	884.2	757.3	822.4	65.10	9.0
<b>Бараг мөнгө</b>	<b>21,994.3</b>	<b>21,568.4</b>	<b>23,166.2</b>	<b>1,597.80</b>	<b>7.0</b>
Төгрөгийн хадгаламж	15,131.5	13,809.6	14,378.6	569.00	4.0
Валютын хадгаламж	4,364.8	4,526.4	5,195.9	669.50	15.0
Валютын харилцах	2,498.0	3,232.4	3,591.7	359.30	11.0
<b>Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө</b>	<b>1,173.7</b>	<b>1,034.9</b>	<b>1,098.5</b>	<b>63.60</b>	<b>6.0</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 6 дугаар сарын байдлаар 25.5 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2.1 их наяд төгрөг буюу 9.0 хувиар өссөн байна.



**Хүснэгт 18. Зээлийн өрийн үлдэгдэл**

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар			Өөрчлөлт (+/-)	
				2023/2022	
	2021	2022	2023	Дүн	Хувь
<b>Зээлийн өрийн үлдэгдэл</b>	<b>19,158.9</b>	<b>23,471.3</b>	<b>25,575.5</b>	<b>2,104.2</b>	<b>9.0</b>
-Хэвийн зээл	16,013.1	20,265.3	22,036.1	1,770.8	8.7
-Хугацаа хэтэрсэн зээл	1,189.7	1,104.2	1,325.4	221.2	20.0
-Чанаргүй зээл	1,956.1	2,101.8	2,214.1	112.3	5.3
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	10.2	9.0	8.7	-	-
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	6.2	4.7	5.2	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 54.9 хувь нь иргэдийнх, 43.8 хувь нь хувийн байгууллагынх байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 6 дугаар сард 22,036.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,170.8 тэрбум төгрөг буюу 8.7 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 86.2 хувийг хэвийн зээл, 8.7 хувийг чанаргүй зээл, 5.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна. Өнгөрсөн онуудын мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь буурсан байна.


**Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл:** 2023 оны 6 дугаар сарын байдлаар хугацаа хэтэрсэн зээл 1,325.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 221.2 тэрбум төгрөг буюу 20.0 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.2 хувийг эзэлж байна.

**Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ:** 2023 оны 6 дугаар сарын байдлаар 2.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 112.3 тэрбум төгрөг буюу 5.3 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 хувийг эзэлж байна.

**Үнэт цаас:** Үнэт цаасны арилжаагаар 2023 оны эхний хагас жилд 512.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Нийт арилжааны 67.3 хувь нь хувьцааны, 17.6 хувь нь хөрөнгө оруулалтын сангийн эрхийн, 13.7 хувь нь компанийн бондын, 8.4 хувь нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна. 2023 оны 6 дугаар сарын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээний дүн 10,996.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2023 оны 6 дугаар сард 36,476.1 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 2,608.8 нэгжээр өссөн байна.

**Валютын ханш:** 2023 оны 6 дугаар сард төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн сарын дундаж 3,438.0 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 314.0 төгрөгөөр суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 480.4 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.9 төгрөгөөр суларчээ. 2023 оны өмнөх сартай харьцуулахад ам.доллар 22.9 төгрөгөөр, юань 15.6 төгрөгөөр тус тус чангараад байна.

**График 13. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн сарын дундаж ханш, 2023 оны 6 дугаар сарын байдлаар, төгрөгөөр**




Эх сурвалж: Монголбанк

**Хэрэглээний үнийн индекс:**

**Хэрэглээний үйлчилгээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 10.6 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 6.3 нэгж хувиар буурсан байна.**

Дэлхийн ихэнх улс орнуудад үүсээд байсан тээвэрлэлтийн хүндрэл, нийлүүлэлтийн саатлууд сүүлийн саруудад намжиж, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт буурсан ч хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөөр байгаа нь инфляц үргэлжлэн өсөхөд голлон нөлөөлж байна. Манай улсын хувьд нэг талаас гадаад орчны таагүй нөхцөл байдал үргэлжлэх, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, зээл, санхүүжилтийн эх үүсвэр хумигдах зэрэг үйл явц эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөх хандлагатай байгаа бол нөгөө талаас хүнсний үнэ өсөх, нийлүүлэлтийн буюу зардлын шалтгаантай инфляц удаан хугацаанд үргэлжлэх эрсдэл тулгарч байна.

**График 14. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт, хувиар**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

#### 4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2023 оны хагас жилийн эцэст 3,818.0 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 721.0 сая ам.доллаар, 2022 оны эцэстэй харьцуулахад 418.0 сая ам.доллаар тус тус өссөн.

**График 15. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллаар/**



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2022 оны эцэст 3,399.6 сая ам.доллар болж импортын 4.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байсан. 2023 оны 6 дугаар сарын эцэст гадаад валютын албан нөөц 3,817.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 23.3 хувь буюу 721.0 сая ам.доллаар өсөж, импортын 5.4 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

#### Хүснэгт 19. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар				
		2019	2020	2021	2022	2023
1	Нийт импорт	2,893.8	2,460.1	3,261.5	3,948.1	4,273.5
2	Гадаад валютын нийт нөөц	4,101.4	3,555.9	4,731.8	3,097.2	3,817.8
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	8.5	8.7	8.7	4.7	5.4

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2023 оны эхний хагас жилийн дүнгээр 7.3 тонн болж, 2022 оны мөн үеэс 0.56 тонноор буурч, сүүлийн 4 жилийн хамгийн бага дүн болж байна.

**График 16. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2012-2023 оны эхний 6 сарын гүйцэтгэл, тонноор**



Эх сурвалж: Монголбанк

#### 4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2023 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 59.9 сая ам.долларын алдагдалтай, харин хөрөнгийн тэнцэл 21.8 сая ам.долларын, санхүүгийн тэнцэл 132.8 сая ам.долларын ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 30.6 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 20.7 сая ам.доллоор нэмэгдсэн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар урсгал тэнцэл 59.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Ийнхүү алдагдалтай гарахад бараа, үйлчилгээний худалдааны тэнцэл 134.4 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч анхдагч орлого 215.7 сая ам.долларын алдагдалтай гарсан нь нөлөөлсөн байна.

#### Хүснэгт 20. Төлбөрийн тэнцэл

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар			Өөрчлөлт
	2021	2022	2023	Дүн
<b>I. Урсгал Тэнцэл</b>	<b>-363.4</b>	<b>-243.1</b>	<b>-59.9</b>	<b>183.2</b>
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-131.8	-101.5	134.4	235.9
В. Анхдагч орлого	-254.0	-164.6	-215.7	-51.1
С. Хоёрдогч орлого	22.4	23.0	21.5	-1.5
<b>II. Хөрөнгийн тэнцэл</b>	<b>10.3</b>	<b>11.4</b>	<b>21.8</b>	<b>10.4</b>
<b>III. Санхүүгийн тэнцэл</b>	<b>17.7</b>	<b>-397.1</b>	<b>-132.8</b>	<b>264.3</b>
<b>IV. Алдаа болон орхигдуулга</b>	<b>84.9</b>	<b>-175.4</b>	<b>-125.3</b>	<b>50.1</b>
<b>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</b>	<b>-285.8</b>	<b>-9.9</b>	<b>-30.6</b>	<b>-20.7</b>

Эх сурвалж: Монголбанк

## ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


### 5.1. Хүн ам, ажил эрхлэлт

2023 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 33.0 мянган хүүхэд шинээр төрж, төрсөн хүүхэд өмнөх оноос 2.8 мянга буюу 9.2 хувиар өссөн байна. 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт ажиллах хүчний тоо 1,231.2 мянга байна. Ажиллах хүчнээс 1,160.3 мянган хүн нь ажилтай, 70.9 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. 2023 оны эхний улиралтай харьцуулахад ажилтай иргэдийн тоо нэмэгдэж, ажилгүй хүмүүсийн тоо буурсан байна. Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 57.9 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.5 хувь байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 896.1 мянга байна. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхжлийг илэрхийлэх үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 1.4 нэгж хувиар буурсан байна.

### 5.2. Ажилгүйдлийн түвшин

2023 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 5.8 хувьтай болж, өнгөрсөн оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс ажилгүй хүний тоо 27.6 мянган хүн буюу 28.1 хувиар буурч, эдийн засаг идэвхжиж ажил эрхлэлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

График 17. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС